

# Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ГСА-2022/05/СТА-ОНӨААН**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Чойр хот 2022 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас:70543156 Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр Утас:70543179 Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Ц.Батсайхан Утас: 70543179 Цахим хаяг: Batsaikhants@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

<b>1. Аудитын санал дүгнэлт</b> .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Дотоод хяналт.....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	7
3.4 Материаллаг байдал .....	8
4. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
4.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	8
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....	8
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	9
5 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
8. Аудитын илрүүлэлт .....	13
8.1 Залруулсан алдаа .....	13
8.2 Төлбөрийн акт .....	13
8.3 Албан шаардлага .....	13
8.4 Зөвлөмж.....	14
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АИТХТ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид
ГСА	Говьсүмбэр аймаг
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

## 1. Аудитын санал дүгнэлт



### ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: goviumber@audit.gov.mn

“ЦӨМ СҮРГИЙН ҮРЖЛИЙН ТӨВ”  
ОНӨҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Г.БАТБАЯР ТАНАА

2022.03.15 № 51  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Сөрөг санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон зүйл

“Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өөрийн орлогын тооцоо бодоогүй, орлогын төлөвлөгөөг биелүүлэх хэмжээний нийт 71,076.6 мянган төгрөгийн 280 хонийг тайлант онд хорогдуулсан, хонийг эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр өмнөх онуудад толгой хамгаалалтад өгсөн нэрээр, мэргэжлийн байгууллагын дүгнэлтгүйгээр хонины арьсыг акталж данснаас хассан зөрчилд тусгайлан хяналт, шалгалт оруулах шаардлагатай гэж үзэж байна.

#### Аудитын гол асуудлууд

“Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй 81,921.7 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 79,861.6 мянган төгрөгөөр их байгаа тул сөрөг санал дүгнэлт өгөхөд нөлөөлсөн байна. Үүнд:

008020147

- Завсрын болон өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй,
- Тайлангийн иж бүрдлийг хангаагүй бөгөөд тайланд тусгагдсан авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,
- Малын тайланг анхан шатны баримтаас зөрүүтэй тайлагнасан,
- Өөрийн орлогыг төлөвлөгөөг биелүүлээгүй,
- Тайлант оны малын нас дэвшилтийг бүртгээгүй,
- Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй,
- Цахим төлбөрийн баримтад хяналт тавиагүй

Эдгээр зөрчлүүд нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6 дугаар зүйлийн 6.5, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "ААНБ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасныг заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### **Бусад асуудал**

"Цөм сүргийн үржлийн төв" ОНӨҮГ-ын данс бүртгэлд тусгагдсан хонины хөдөлгөөний тайлангууд тоо толгой, хүйсийн зөрүүтэй илэрхийлэгдсэн нь зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүссэн.

#### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

"Цөм сүргийн үржлийн төв" ОНӨҮГ нь тайлант хугацаанд ТЕЗ-аас төсвийн шууд захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөг 80.3%-тай хэрэгжүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



## **2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

---

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

---

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайланг хуулийн хугацаанд үнэн зөв бэлтгэх талаар зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн санхүүгийн тайланг холбогдох байгууллагуудаар баталгаажуулж, 03 дугаар сарын 10-нд хуульд заасан хугацаанаас 23 хоног хоцроож ирүүлсэн байна.

#### **3.2 Дотоод хяналт**

Тус төвийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас тус төвийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, тус шалгалтаар 21,790.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 474.9 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгохоор төлбөрийн акт тогтоож, 275.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн байна.

Хяналт шалгалтын байгууллагаас өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж, төлбөрийн актыг барагдуулж ажиллаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн зардлын 171,680.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 2.575.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2,060.1 мянган төгрөгөөр тогтоосон

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4. Санхүүгийн тайлангийн тодруулга**

### **4.1 Байгууллагын үйл ажиллагаа**

Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ-ын зорилго нь Сүмбэр хонины тоо, толгойг нэмэгдүүлж, хурганы арьс бэлтгэн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд оршино.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Сүмбэр үүлдрийн хонины удмын сан, генетик, нөөцийг хадгалах, тоо толгойг өсгөх, үржлийн ажил үйлчилгээ, бүртгэл, мэдээллийг мэргэжлийн үндсэн дээр гүйцэтгэх үйл ажиллагааны чиглэл статустай байна.

### **4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин**

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Энэ хүрээнд ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-т “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргаагүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого**

Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдээгүй материаллаг хэмжээний алдаатай байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.4		-0.4
БХХО			0.0
Авлага	15,180.6	10,905.3	-4,275.4
Урьдчилгаа			0.0
Бараа материал	459,353.7	371,504.5	-87,849.2
Үндсэн хөрөнгө	83,441.4	75,128.7	-8,312.7
Биет бус хөрөнгө	16,200.0	0.0	-16,200.0
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>574,176.2</b>	<b>457,538.5</b>	<b>-116,637.7</b>
Өр төлбөрийн дүн	10,989.4	6,584.0	-4,405.4
Богино хугацаат өглөг	10,989.4	6,584.0	-4,405.4
Урт хугацаат өглөг			0.0
Эздийн өмч	563,186.8	450,954.5	-112,232.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>574,176.2</b>	<b>457,538.5</b>	<b>-116,637.7</b>

Мөнгөн хөрөнгийн дансыг үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Авлага дансны үлдэгдэл 10,905.3 мянган төгрөг болж 4,275.4 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь өмнөх оны хонины авлагаа барагдуулснаас шалтгаалжээ.

Авлагын үлдэгдэлд байгууллагаас авах авлага 2,429.3 мянга, хувь хүнээс авах авлага 8,476.0 мянга төгрөг тус тус байна. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 371,504.5 мянган төгрөг болж 87,849.2 мянган төгрөгөөр хасагдсан нь тусгай зориулалтын материал акталсан, малын хорогдол зэргээс хасагдсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 459,353.7 мянган төгрөг байснаас тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 25,100.9 мянга, арьсны орлого 9,425.0 мянга, төлийн орлого 12,450.0 мянга, АИТХТ-ийн 2021.12.30-ны өдрийн 48 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгөөс бараа материалын дансанд шилжүүлсэн 5,650.0 мянга, барилгын засварын материалын данснаас аж ахуйн материалын дансанд шилжүүлсэн 73.5 мянга, нийт 52,699.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 35,980.9 мянга, данснаас дансанд шилжүүлсэн 73.5 мянга, тус төвийн захирлын 2021.07.09-ний өдрийн А/04 дүгээр тушаалаар акталсан 30,822.2 мянга, хорогдсон хонь 67,177.0 мянга, худалдсан хонь 5,620.0 мянга, худалдсан арьс 875.0 мянга, нийт 140,548.6 мянган төгрөгөөр хасагдаж, 371,504.5 мянган төгрөгийн материалын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 75,128.7 мянган төгрөг болж 57,685.2 мянган төгрөгөөр буурсан нь ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг акталсан, үндсэн хөрөнгөнд

бүртгэлтэй хонийг зарцуулж, бараа материалын данс руу шилжүүлсэн зэргээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 174,443.5 мянган төгрөг байснаас 2021.12.30-ны 52 дугаар тогтоолоор ашиглалтын хугацаа дууссан 6 нэр төрлийн 23,682.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 6050.0 мянган төгрөгийн хонийг худалдаж, 4,500.0 мянган төгрөгийн хонийг акталж, 5,650.0 мянган төгрөгийн хонийг бараа материалын дансанд шилжүүлж, нийт 39,822.5 мянган төгрөгөөр хасагдаж, 134,561.0 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Биет бус хөрөнгө данс тайлант онд өөрчлөгдөөгүй байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 6,584.0 мянган төгрөг болж 4,405.4 мянган төгрөгөөр буурсан бөгөөд өмнөх оны өглөгийг бүрэн барагдуулж ажиллаагүйтэй холбоотой байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл нь бараа ажил үйлчилгээний зардлын өглөг 6,550.0 мянга, байгууллагад төлөх өглөг 34.0 мянган төгрөг тус тус байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 450,954.5 мянган төгрөг болж 112,232.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлан хугацааны үр дүнгээр хасагдсан байна.

Аймгийн Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ-ын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 65,958.3 мянган төгрөгөөр буюу 31.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь санхүүжилтийн орлого 14,248.3 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материалын орлого 66,648.5 мянган төгрөгөөр тус тус буурч, үндсэн үйл ажиллагааны орлого 14,938.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Энэ нь санхүүжилтийн орлого өмнөх оноос буурсан, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө хүлээн аваагүй зэргээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 94,169.1 мянган төгрөгөөр буюу 58.4 хувиар нэмэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардал нь хангамжийн бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардал тус тус байна.

Энэ нь тайлант онд бараа материал акталсан, өмнөх жилүүдэд толгой хамгаалалтад өгсөн хонийг данснаас хассан, хонь хорогдсон зэрэг нь нөлөөлжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

#### **4.4 ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

##### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 326.488.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 326,488.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 196,488.8 мянган төгрөгөөр бууруулж, 130,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн төсөлд тусгагдсан саналаас цалин, НДШ-ийн зардлыг 62,110.6 мянга, хангамжийн материалын зардлыг 1,676.8 мянга, байр ашиглалтын тогтмол зардлыг 7,655.9 мянга, нормативт зардлыг 14,784.9 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 26,230.5 мянга, дотоод албан томилолтын зардлыг 4,588.0 мянга, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 8,945.4 мянга, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зардлыг 69,496.7 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 1,000.0 мянга, нийт 196,488.8 мянган төгрөгийн зардлыг хасаж баталсан байна.

Анх 148,564.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд төсвийн тодотголоор өөрчлөлт ороогүй байна.

### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “70801- Мал аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 80101-үндсэн үйл ажиллагааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 113,126.9 мянга, 81305-өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр 16,873.1 мянга, нийт 130,000.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 99,058.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 30,941.2 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс санхүүжилт 99,058.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 26,338.6 мянга, нийт 125,397.4 мянган төгрөгийн санхүүжилт, орлого бүрдүүлж 125,054.6 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 125,054.2 мянган төгрөг буюу 96.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны орлогыг төлөвлөгөөг 4,602.5 мянган төгрөгөөр дутуу биелүүлснээс зардлын бодит бус хэмнэлт, 343.3 мянган төгрөгийн бодит хэмнэлт гарсан байна.

Тайлант онд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 343.3 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн үр дүнгийн тайланд санхүүжилт 99,058.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 22,082.7 мянга, төлийн орлого 12,450.0 мянга, арьсны орлого 9,425.0 мянга, нийт 143,016.5 мянган төгрөгийн санхүүжилт, орлогыг тайлагнасан байна.

Мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилт 99,058.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 26,338.6 мянга, нийт 125,397.4 мянган төгрөгийн санхүүжилт, орлогыг тайлагнасан байна.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ гараагүй байна.

## **5 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус төвийн 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

## 5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 147 мэдээллээс Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 20,321.8 мянган төгрөгийн 10 мэдээллээс таван сая төгрөгөөс дээш нийт 2 худалдан авалтын 12,31.8 мянга, таван сая төгрөгөөс дээш нийт 2 зарлагын 8,000.0 мянган төгрөгийн гүйлгээ, хөрөнгө зарцуулах 7 тушаалыг тус тус мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 37,511.5 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчил илэрч үүнээс 26,553.0 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага өгч, 600.3 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 10,358.2 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгснөөс 600.3 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2 албан шаардлагыг хэрэгжүүлж, 26,553.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 10,358.2 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	600.3	1	600.3			
Албан шаардлага	4	26,553.0	2	0	2	26,553.0	50%
Зөвлөмж	3	10,358.2	0	0	3	10,358.2	0 %
Нийт дүн	10	37,511.5	3	600.3	5	36,911.2	

Завсрын аудитаар нийт 26,605.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,600.3 мянган төгрөгийн 2 алдааг залруулах, 25,005.2 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснөөс жилийн эцсийн байдлаар 2 алдааг залруулж, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аймгийн Цөм сүргийн үржлийн төвийн үйл ажиллагаанд малын тайланг анхан шатны баримтаас зөрүүтэй тайлагнасан, авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, өөрийн орлогыг төлөвлөгөөг биелүүлээгүй, тайлант оны малын нас дэвшилтийг бүртгээгүй, арьс, хонийг эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй данснаас хассан, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг давтан гаргасан, аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг биелүүлээгүй зэрэг анхаарал татахуйц асуудал байгаа тул аймгийн ИТХ-д хүсэлт гаргаж хонь, арьсны тооцоонд тусгайлсан хяналт, шалгалт хийлгэх шаардлагатай байна.

## **8. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 118,457.1 мянган төгрөгийн 10 алдаа зөрчил илэрснээс 36,535.4 төгрөгийн 5 алдааг залруулж, 484.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 81,437.1 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өглөө. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүн тогтоосон материаллаг байдлаас өндөр дүнтэй, санхүүгийн тайлан илтэд алдаатай тул санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгч байна.

### **8.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 36,535.4 мянган төгрөгийн 5 алдаанаас 1,600.3 мянган төгрөгийг 2 алдааг завсрын аудитаар 34,935.1 мянган төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайлангийн аудитаар тус тус залруулав. Үүнд:

- 8.1.1** Төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого, зарлагын төлөвлөгөөг 1,423.1 мянган төгрөгөөр илүүг тайлагнасныг завсрын аудитаар залруулсан
- 8.1.2** Мөнгөн гүйлгээний тайланд орлогын гүйцэтгэлийг 177.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг завсрын аудитаар залруулсан
- 8.1.3** Бараа материалын тодруулга тайлан үнэ төлбөргүй хүлээн авсан төл, арьсны орлогын 21.875.0 мянган төгрөгийг төсвийн хөрөнгөөр худалдан авснаар тайлагнасан
- 8.1.4** Санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн данснаас бараа материалын дансанд шилжүүлсэн 5,650.0 мянган төгрөгийн 113 хонийг орлого, зарлагаар тусгасан
- 8.1.5** Санхүүгийн үр дүнгийн тайланд акталж устгасан 7,410.1 мянган төгрөгийн хонийг үнэ төлбөргүй гарсан зардлаар тайлагнасан

### **8.2 Төлбөрийн акт**

- 8.2.1.** Аймгийн Засаг даргын захирамжийг хэрэгжүүлээгүй, захирлын цалингаас 484.6 мянган төгрөгийн арга хэмжээний суутгалыг тооцож аваагүй байна Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5 заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн орлого болгохоор төлбөрийн акт тогтоов.

### **8.3 Албан шаардлага**

- 8.3.1** Өөрийн орлогын төлөвлөгөөг 4,602.5 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалтуудыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

- 8.3.2** Цалингийн зардлаас барилгын засварын гэрээт ажлын хөлс 1,185.0 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв

- 8.3.3** Тайлант онд авлага, өглөгийг барагдуулж ажиллаагүй, авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, шилэн дансны хуулийг хэрэгжүүлж

ажиллаагүй, цахим төлбөрийн баримтад хяналт тавиагүй, малын тайланг зөрүүтэй бэлтгэсэн, эрх бүхий албан тушаалтны шийдвэр, анхан шатны баримтгүй арьс, хонийг данснаас хассан, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Эдгээр нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6 дугаар зүйлийн 6.5, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "ААНБ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, байгууллагын нягтлан бодогчид хариуцлага тооцох албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

#### **8.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн аудитаар ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусгахдаа үнэн зөв бүртгээгүй, аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, 20.2.5 дахь заалтуудыг хэрэгжүүлж, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/ Мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Аймгийн Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ	9	98,135.3	5	36,535.4	1	484.6	2	61,115.3	1	
Дүн		9	98,135.3	5	36,535.4	1	484.6	2	61,115.3	1	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Аймгийн Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ	1	20,321.8					1	20,321.8		
Дүн		1	20,321.8					1	20,321.8		
Нийт дүн		10	118,457.1	5	36,535.4	1	484.6	3	81,437.1	1	